

## СТРАТЕГИЙН АШИГТ МАЛТМАЛЫН АЧ ХОЛБОГДЛЫН ТУХАЙ

С.АВИРМЭД

МУИС, Газарзүй Геологийн Сургууль

Ашигт малтмалын стратегийн ач холбогдолын тухай сүүлийн үед их ярих боллоо. Стратегийн орд гэх үү, стратегийн ашигт малтмал гэх үү гэх сэдвээр маргаан өрнөх төлөвтэй. Ашигт малтмал гэдэг нь ерөнхий, орд гэвэл нарийвчилсан ойлголт болж байна. Олон зуун сая жилийн турш байгаль өөрөө бутээж бий болгосон, хэзээ нэгэн цагт шавхагдаж дуусах ашигт малтмал, эрдэс баялаг нь бүхэлдээ стратегийн ач холбогдолтой болох нь бүгдэд ойлгомжтой баймаар. Харин улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг гол нэр төрлийн, их нөөц баялагтай ашигт малтмалын томоохон ордууд стратегийн ач холбогдолтой болох нь бас хэний ч эргэлзээ төрүүлэхгүй байх. Чухам энэ ойлголтын үндсэн дээр Монгол улсын ашигт малтмалын тухай хуульд: **“стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд”** гэж үндэсний аюулгүй байдал, улсын болон бус нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг; хэлнэ гэсэн заалтыг тухайн үед бид санаачилсан юм. Гэтэл энэ заалтыг өөрчлөх, бүр хасах тухай зарим улс төрчид ярьж эхэллээ. Гол шалтгаан нь, “стратегийн гэж юу хэлэх гээд байгаа нь тодорхой бус, хөрөнгө оруулагчдыг үргээчихнэ” гэж тэд үзэж байгаа аж. Хүн амтай нь харьцуулах юм бол манай улс асар уудам нутаг дэвсгэртэй юм. Энэ нь эдийн засгийг хөгжүүлэхэд зайлшгүй харгалзаж үзэх ёстой хучин зүйл мөн. Үүнийг дээрх тодорхойлотод харгалзсан. Ухаандаа, Улаанбаатарын хажууд байгаа нэг ордыг ашиглах, дэд бүтцийн хөгжил сүл Баян-Өлгийд байгаа нэг ордыг ашиглах эдийн засгийн үр ашиг нь харилцан өөр байна гэдгээр энэ нь тайлбарлагдаж байгаа юм.

Улсын болон бус нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний гэдэг нь том ордууд байхаас гадна, орон нутгийн хөгжил, тухайлбал, монгол улсыг 4-5 эдийн засгийн районд буюу, Өрнөт, Хангайн, Төвийн, Дорнот бус нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэх, ямарч төрлийн, хичнээн ч хэмжээний нөөц баялагтай орд байж болох юм. Эдгээрийг төрийн эрх бүхий мэрэгжлийн байгууллага тусгай шалгуураар тодорхойлох шаардлагатай байсан. Гэтэл төрийн эрх бүхий байгууллага ийм шалгуур аргачлалыг гаргасангүй, тэрч байтугай хуулийн дээрх заалтыг сайтар ойлгосонгүй, стратегийн ордуудын жагсаалтыг гаргаж, түүнийг нь Засгийн газар, УИХ мөн л сайтар хянаж, хэлэлцсэнгүй, 15 ордыг стратегийн ангиллаар, 39 ордыг стратегийн ордод хамааруулах саналыг дахин судалж оруулж ирэхийг Засгийн газарт үүрэг болгож, УИХ-ын 2007 оны 2 дугаар сарын 6-ны 27 дугаар тогтоолоор үүнийг баталгаажуулжээ.

Хамгийн сонирхолтой агаад, инээдтэй ч, эмгэнэлтэй ч гэмээр баримт нь бүр 90 оноос өмнө нөөцийг нь ашиглаж дууссан Хонгорын хайлуур жоншны ордыг эдгээр

39 ордын жагсаалтад оруулсан нь УИХ-аар баталсан баримт бичгийг “юмаа мэддэгүй хүн” хийж, мөн юмаа мэддэггүй гишүүд, засгийн газар, яам үүнийг оруулжээ гэх дүгнэлтэд хүргэж байгаа юм.

Өнөөгийн байдлаар, дөч гаруй төрлийн ашигт малтмалын 1000 гаруй ашиглах тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Энэ нь үндсэндээ Монгол улсад ийм тооны ашигт малтмалын орд байна, бас уурхайн үйлдвэр байна гэж үзэх үндэстэй. Үүнээс үзвэл монгол улсын бүх ашигт малтмалын ордын нэг орчим хувийг л стратегийн ашигт малтмалын ордод хамруулсан нь үнэхээр чамлалттай үзүүлэлт юм.

**Аливаа ордыг стратегийн ордод хамруулах нь, төрийн, олон нийтийн өмчийг тэдний мэдэлд байлгаж, тэдгээрийг ашигласнаас гарах үр ашгийг ард иргэдэд аль болох илүү хүртээх гол зорилготойгоос гадна, бас улам бүр ховордож, шавхагдаж байгаа байгалийн баялгийг ариг гамтай, хамгаалж, хямгадаж ашиглах бодлогыг хэрэгжүүлэхэд оршино гэж тодорхойлж болно.**

Тэгэхээр стратегийн ордыг тодорхойлох шалгуур, аргачлалыг боловсруулах нь нэн тэргүүний зорилт болж байгаа юм. Стратегийн ашигт малтмал гэж ярих уу, стратегийн орд гэж ярих уу гэдгийг юуны түрүүнд ойлголцмоор байна. Орд биш, ашигт малтмалын тухай авч үзэх нь илүү өргөн хүрээтэй асуудал юм. Ордын тухай авч үзвэл, энэ нь үндсэндээ нэр төрлөөс гадна, нөөц баялгийн тоо хэмжээ, чанар, эдийн засгийн ач холбогдолоороо тодорхойлогдоно. Харин Ашигт малтмалын тухай яривал, тэр нь үндсэндээ түүний нэр төрлөөр нь тодорхойлогдоно. Эндээс стратегийн ашигт малтмал, стратегийн орд гэх ойлголтууд аль аль нь байж болох юм, байх ёстой гэж үзэж байна. Харин стратегийн ашигт малтмал гэдэг нь стратегийн ордоо агуулж байгаа өргөн хүрээтэй ойлголт ажээ. Зарим улс оронд стратегийн ашигт малтмал хэмээх ойлголтод бүх төрлийн ашигт малтмал, хэтрүүлж хэлвэл, Менделеевийн уелэх системийн бараг бүх элементийг оруулжээ. Харин манай өнөөгийн зарим улс төрчид үнэт металл, сацраг идэвхит эрдэс, эрчим хүчний түүхий эд, үнэт чулуу зэрэг хуруу дарам хэдэн нэр төрлөөр стратегийн ашигт малтмалыг хязгаарлах гэж оролдож байгаа нь гэнэн агаад ихээхэн хортой үр дагавартай юм.

Ашигт малтмалыг нэр төрлөөр нь стратегийн ангилалд хамааруулах нь харьцангуй хялбар ажил байж болох юм. Монгол улсын хувьд авч үзвэл, зэс, төмөр, хайлуур жонш, фосфор, полиметалл, цагаан тугалга, вольфрамын ордуудыг стратегийн ашигт малтмалд оруулахгүй байж болохгүй. Зарим металлын шороон ордыг ч стратегийн ордод хамруулах санал байдаг. Тухайлбал хялбар аргаар ашиглаж, өндөр үр ашиг олж болох алтны шороон ордуудыг стратегийн ордод олруулж гэсэн санал бүр ерээд оны эхнээс гарч байсан бөгөөд одоо эргээд үзэхэд энэ нь чухал ач холбогдорлтой байжээ гэдэг нь улам бүр ойлгомжтой болсоор байна. Мөн ниоби, tantal, рубиди, цези, литийн ордуудыг дэлхий даяар стратегийн түүхий эдэд тооцдогийг харгалзаж үзэх нь зайлшгүй. Энэ талаас үзвэл стратегийн ашигт малтмалын нэр төрлийг тодорхойлох нь тийм төвөгтэй асуудал биш.

Ерөнхийдөө ашигт малтмалыг ердийн, түгээмэл гэж ерөнхий ангилаад түүнээсээ стратегийнхыг ялгаж болох байх. Өөрөөр хэлбэл стратегийн ордыг ялгасанаас түгээмэл тархацтай ордыг ялгасан нь ч илүү амар байж болох юм.

Хамгийн ойлгомжтой бөгөөд, хялбар ойлголт бол тухай ордын нөөц баялгийн тоо хэмжээг харгалзан стратегийн ордод нийтлэг шалгуур бий. Энэ нь том, маш том

ордыг стратегийн ордод хамаруулах шалгуур юм. Тэгвэл өнөөгийн байдлаар монгол улсад ямар нөөцтэй ордыг томд хамаруулах вэ гэдэг нь ойлгомжгүй, энэ нь нөөцийн тоо хэмжээний ангилалтай шууд холбоотой. Ийм ангилал одоогоор алга байна. Олон жилийн турш тухайн үеийн ЗХУ-д мөрдөж байсан ангиллыг ашиглаж байсан. ЗХУ бол тухайн үеийн дэлхий хуурай газрын тал хувийг эзэлсэн, том гүрэн төдийгүй, түүхий эдийн асар их хэрэгцээтэй улс орон байв. Тэгвэл энэ улсын эрдэс баялгийн нөөцийн ангиллыг жижиг эдийн засагтай, эрдэс түүхий эдийн бага хэрэгцээтэй улс орон авч хэрэглэнэ гэдэг нь учир дутагдалтай төдийгүй, үндэслэлгүй юм. Эндээс ямар дүгнэлт хийж болох вэ гэхээр, өөрийн орны эдийн засгийн багтаамж, эрдэс түүхий эдийн хэрэгцээ, экспортодыг харгалзсан эрдэс баялгийн нөөц баялгийн ангиллыг боловсруулах нь гол зорилтын нэг гэж үзэж байна. Стратегийн ашигт малтмалыг тодорхойлох өөр нэг шалгуур үзүүлэлт бол тухайн ордын газар зүй эдийн засгийн байршил юм. Монгол улсын өргөн уудам газар нутгийн хаана, дэд бүтцийн ямар хөгжилтэй газар нутагт байршиж байна, алс бөглүүд газар байна уу гэдгээс тухай ордын эдийн засгийн ач холбогдол тодорхойлогдоно.

Стратегийн ордыг тодорхойлох өөр бас нэг үзүүлэлт бол тухай ордын олборлолтын нөхцөл, геологийн тогтоцын онцлог юм. Үүнийг эдийн засгийн хэлээр уурхайн рент ч гэж нэрлэх нь бий. Бас зарим нь, уул техникийн нөхцөл гээд зуршчихсан тал бий. “Уул техник” гэдэг нь орос хэл дээр “горно-технический” гэх үгээс гаралтай бөгөөд монгол дээр үгчилвэл, уул техник гэж боломоор авч, үнэндээ энэ хам уг, монгол уг биш гэдэг нь тодорхой. Харин үнэндээ, олборлох нөхцөл гэхэд л монгол хүн амархан ойлгоно. Өөрөөр, энгийн үгээр хэлвэл, хүдэр чулууг ухаж гаргах, уурхайлах нөхцөл гэхэд хэн бүхэнд ойлгомжтой байх. Ашигт малтмалыг олборлох нөхцөл нь хүдрийн биетийн хэлбэр хэмжээнээс авхуулаад, ашигт эрдсийн тархалт, зузаалгийн өөрчлөлт, хувиран өөрчлөгдхөн чанар, хүдэр чулуулгийн хатуулаг зэрэг олон ойлголтыг багтааж байдаг. Эдгээрээс хамгийн гол үзүүлэлт бол ашигт малтмалын биетийн орших гүн үүнээс хамаарсан ашигт малтмалыг олборлох арга юм. Энэ шалтуураар эрдэс баялгийг ил ба далд аргаар олборлох эсэх нь тодорхойлогдоно. Ил аргаар ашиглах зардал гэхэд л хучдас хуулалтын коэффициентээс хамаараад хүдэр олборлох зардал нь өөр хоорондоо хэд дахин ялгагдана. Мэдээж, ил далд аргын хооронд ч зардлын их ялгаа гарна. Энэ бүхэн нь ордыг ашиглах эдийн засгийн үр ашигт шууд нөлөөлнө. Энгийн бөгөөд ойлгомжтой юмыг нуршдагийн учир гэвэл, стратегийн ордыг тодорхойлох гол хүчин зүйлүүдийн нэг бол геологийн тогтоц, олборлох нөхцөлийг стратегийн ордыг тодорхойлох нэг хүчин зүйлийн нэг мөн, үүнийг харгалзах шалгуурыг гаргах учиртай гэдгийг л хэлэх гэсэн юм. Дээр тодорхойлсоноос дүгнээд хэлвэл, стратегийн ордыг тодорхойлоходоо, бус нутгийн байршил буюу газар зүй эдийн засгийн байршил, тухай газар нутгийн дэд бүтцийн хөгжлийг харгалзахаас гадна, тухай ордын геологийн тогтоцын онцлог, олборлох нөхцлийг мөн нэг шалгуур болгож үзэх ёстой. Газар нутгийн байршил шийдвэрлэх ач холбогдолтой гэдгийг зарим нэг жишээн дээр тайлбарлаж болох юм. Баруун бус нутгийг аваад үзье. Улс орныг хөгжүүлэх үндэс нь үйлдвэржүүлэх гэдэгтэй хэн ч маргахгүй байх. Тэгвэл үйлдвэржилтийн үндэс нь төмөр ган хайлуулах үйлдвэр барих, эрчим хүчээр хангах, барилгажуулах гэдэгтэй бас хэн ч маргахгүй байх. Тэгвэл энэ бус нутгийн төмрийн хүдэр, өндөр чанарын коксжих нүүрсийг хэмжээ хязгаартгүй

экспортлох бодлого баримтлах нь буруу , харин эдгээрийг экспортлохгүй байх, эсхул, хязгаартай экспортлох бодлогыг одооноос хэрэгжүүлэх нь гол асуудал болж байна. Үйлдвэржилт, барилгажилтын үндэс нь цементийн үйлдвэр, иймээс цементийг “үйлдвэрийн талх” ч гэж ярилцдаг. Баруун бус нутаг , өнөөдөр цементийнхээс хэрэгцээг өмнөт хөршөөс эсхүл нийслэл хангаж байгаа болов уу. Алт болж очно. Гэтэл Ховд аймагт , аймгийн төвийн хажууханд цементийн гол түүхий эд болох шохойн чулууны “сайхан” ордын нөөцийг гучаад жилийн өмнө тодорхойлсон байдаг. Тэгвэл энэ орд, миний бодлоор баруун бус нутгийн хувьд, стратегийн ордод хамрагдана гэдэгт эргэлзэх зүйлгүй. Энэ мэтчилэн бус нутаг болгонд нэр төрлөөр нь, нөөц баялгийн тоо хэмжээгээр нь нийгэм эдийн засагийн ач холбогдолор нь стратегийн ашигт малтмал, ордыг ялгаж болно. Харин ашигт малтмалын тухай хуульд, стратегийн ашигт малтмал, ордын тухай өөрчлөлт оруулах гэж байгаа бол одоо байгаа заалт дээр нэмж ямар төрлийн ашигт малтмалын стратегийн болох талаар тусгаж өгөх нь зүйтэй. Гэхдээ стратегийнашигт малтмалын ордыг тодорхойлох хууль эрх зүй, газарзүй эдийн, олборлолтын нөхцөлийг тодорхойлох шалгуур аргачлалыг боловсронгуй болгох нь гол чухал зорилт юм.